

“ӨНДӨРХААН” ХК

2024 оны 12 сарын 30-ны өдөр

№24/.15

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
бус хурлыг хойшлуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэг, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.3, 69.6 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам” болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өндөрхаан” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 10:00 цагт товлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ын ирц хүрээгүй тул хурлыг 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт болгон танхим хэлбэрээр дахин хуралдуулж хойшлуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, холбоотой бусад баримт бичгийг бэлэн болгож 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.

7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.
8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга:
ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг
Хурал байгуулах комиссын гишүүд:
Гүйцэтгэх захирал Ц.Тайшир
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Тооллогын комиссын дарга:
Б.Батжаргал Барристер Кастос Хуулийн фирм
Тооллогын комиссын гишүүн:
Г.Энхжин Барристер Кастос Хуулийн фирм
Ц.Энхбаяр Барристер Кастос Хуулийн фирм
10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ